

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/34/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2023 он

Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын
газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Энхжавхлан
Утас: 261945 Цахим хаяг: enkhjavkhants@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Ахлах аудитор: Р.Цолмон
Утас:261628 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn
Аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 261628 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
С.ЧИНЗОРИГ ТАНАА

2023.04.25 № 917
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлагыг барагдуулаагүй, тайлант онд үүссэн авлага болон өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, сангийн мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлээгүй зэрэг 195,216.9 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн байна.

Эдгээр нь УСНББОУС болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцыг өргөжүүлэн 705 оношийн хамааралтай бүлгээр хэвтүүлэн эмчлэх болон мэс заслын эмчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас 80-100 хувь хариуцдаг болсон байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын санд Капитал банкнаас хүлээн авсан үл хөдлөх хөрөнгийг борлуулан 5,572.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай” 13 дугаар тогтоолоор эрсдэлийн сангийн 40,000.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт “ТЭЗ нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийн 29.5 “Эрүүл мэндийн даатгал” хөтөлбөрт 2 хүрэх үр дүнг баталсан бөгөөд хэрэгжилтийг 96.7 хувь гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	589,644,216.3	323,362,726.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	422,217,333.9	170,365,956.4
33	АВЛАГА	124,282,718.5	106,205,906.8
34	УРЬДЧИЛГАА	6,464,776.9	1,646,539.8
35	БАРАА МАТЕРИАЛ	36,679,387.0	45,144,323.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,268,564.6	9,048,625.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,268,564.6	9,048,625.5
39200	Биет хөрөнгө	3,550,719.1	3,309,095.0
39300	Биет бус хөрөнгө	1,717,845.5	5,739,530.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	594,912,780.8	332,411,352.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	268,134,100.6	60,591,098.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	268,134,100.6	60,591,098.8
41300	Өглөг	268,131,826.7	60,581,084.1
41400	Урьдчилж орсон орлого	2,274.0	10,014.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	326,778,680.2	271,820,253.2
51	Засгийн газрын хувь оролцоо	326,778,680.2	271,820,253.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	13,793.9	13,793.9
51200	Хуримтлагдсан үр дүн	326,764,886.3	271,806,459.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	594,912,780.8	332,411,352.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,283,487,916.4	1,514,581,298.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	83,951,321.0	163,708,631.7
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	83,951,321.0	163,708,631.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,304,176.3	2,630,339.4
120	Нийтлэг татварын бус орлого	10,304,176.3	2,629,463.0
122	Тусламжийн орлого	-	876.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,189,232,419.1	1,348,242,327.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,755,326,405.4	1,569,163,812.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,755,326,405.4	1,569,163,812.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,802,960.4	9,602,781.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,736,939.5	4,452,404.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	481,499.1	580,155.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,544.1	170,987.3
2104	Хангамж, бараа материалын зардал	353,157.3	356,014.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	319,564.8	19,711.8
2107	Томилолт, зочны зардал	63,886.0	108,241.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,895,086.1	1,873,198.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	836,283.5	2,042,069.0
212	ТАТААС	68,948,753.0	80,761,860.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,628,574,692.0	1,478,799,169.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(471,838,489.0)	(54,582,513.8)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	37,021.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,867.1	51,592.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(471,846,356.0)	(54,597,084.8)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	798,897,516.2	798,897,516.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(272,480.0)	(272,480.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	798,625,036.2	798,625,036.2
4	Тайлант үеийн үр дүн	(471,846,356.0)	(471,846,356.0)
5	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,778,680.2	326,778,680.2
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(361,342.2)	(361,342.2)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	326,417,338.0	326,417,338.0
8	Тайлант үеийн үр дүн	(54,597,084.8)	(54,597,084.8)
9	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	271,820,253.2	271,820,253.2

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,300,374,812.7	1,567,513,778.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,002,031,692.8	-
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,002,031,692.8	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,678.5	40,000,842.0
120	Нийтлэг татварын бус орлого	5,678.5	40,000,842.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	298,337,441.4	1,527,512,936.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,493,637,099.7	1,801,990,617.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,493,637,099.7	1,801,990,617.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,639,231.2	51,025,964.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,445,241.1	4,466,344.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	635,635.8	569,926.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,614.1	171,917.3
2104	Хангамж, бараа материалын зардал	180,189.2	213,301.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	302,352.0	39,736.5
2107	Томилот, зочны зардал	68,704.4	111,395.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,190.0	1,902,377.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,383,304.7	43,550,965.6
212	ТАТААС	61,166,336.2	92,362,381.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,386,831,532.3	1,658,602,271.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(193,262,287.0)	(234,476,838.9)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,776,625.1	17,374,538.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,776,625.1	17,374,538.6
2200	Дотоод эх үүсвэрээр	1,776,625.1	17,374,538.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,776,625.1)	(17,374,538.6)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(195,038,912.2)	(251,851,377.5)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	617,256,246.1	422,217,333.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	422,217,333.9	170,365,956.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,344,969,172,700.00	1,472,777,373,444.40	(127,808,200,744.40)	109.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,481,369,172,700.00	1,480,083,693,972.49	1,285,478,727.51	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,949,332,000.00	53,099,005,822.25	850,326,177.75	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,788,466,200.00	4,466,344,219.46	322,121,980.54	93.3
210101	Үндсэн цалин	3,133,709,700.00	2,625,603,968.41	508,105,731.59	83.8
210102	Нэмэгдэл	575,304,600.00	1,172,727,926.81	(597,423,326.81)	203.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	649,264,000.00	389,270,058.68	259,993,941.32	60.0
210104	Урамшуулал	430,187,900.00	278,742,265.56	151,445,634.44	64.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	661,596,100.00	569,926,656.19	91,669,443.81	86.1
210201	Тэтгэврийн даатгал	465,567,600.00	364,222,206.92	101,345,393.08	78.2
210202	Тэтгэмжийн даатгал	49,007,100.00	74,155,175.18	(25,148,075.18)	151.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	39,205,700.00	33,682,388.95	5,523,311.05	85.9
210204	Ажилгүйдлийн даатгал	9,801,500.00	9,956,106.23	(154,606.23)	101.6
210205	Эрүүл мэндийн даатгал	98,014,200.00	87,910,778.91	10,103,421.09	89.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	219,500,000.00	171,917,311.94	47,582,688.06	78.3
210301	Гэрэл, цахилгаан	41,000,000.00	49,981,737.25	(8,981,737.25)	121.9
210302	Түлш, халаалт	45,000,000.00	36,512,611.39	8,487,388.61	81.1
210303	Цэвэр, бохир ус	25,000,000.00	12,439,923.30	12,560,076.70	49.8
210304	Байрны түрээс	108,500,000.00	72,983,040.00	35,516,960.00	67.3
2104	Хангамж, бараа материалын зардал	245,206,400.00	217,441,027.00	27,765,373.00	88.7
210401	Бичиг хэрэг	59,713,000.00	91,632,604.68	(31,919,604.68)	153.5
210402	Тээвэр, шатахуун	25,813,400.00	17,313,000.00	8,500,400.00	67.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	67,000,000.00	33,685,583.32	33,314,416.68	50.3
210404	Ном, хэвлэл	-	44,110.00	(44,110.00)	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,680,000.00	74,765,729.00	17,914,271.00	80.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	195,000,000.00	180,283,311.00	14,716,689.00	92.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	146,000,000.00	136,233,511.00	9,766,489.00	93.3
210602	Тавилга	9,000,000.00	4,049,800.00	4,950,200.00	45.0
210604	Урсгал засвар	40,000,000.00	40,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	153,050,000.00	111,395,427.00	41,654,573.00	72.8
210702	Дотоод албан томилолт	153,050,000.00	111,395,427.00	41,654,573.00	72.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,454,326,600.00	7,180,156,621.66	274,169,978.34	96.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	490,077,600.00	419,619,890.00	70,457,710.00	85.6
210803	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	1,999,136.00	864.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,000,000.00	968,758.00	1,031,242.00	48.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	476,400.00	470,000.00	6,400.00	98.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,955,473,800.00	6,756,538,038.66	198,935,761.34	97.1
210807	Газрын төлбөр	938,800.00	365,299.00	573,501.00	38.9

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,360,000.00	195,500.00	3,164,500.00	5.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,232,186,700.00	40,201,541,248.00	30,645,452.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,159,020,900.00	40,156,499,748.00	2,521,152.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	73,165,800.00	45,041,500.00	28,124,300.00	61.6
212	ТАТААС	67,306,200,000.00	67,299,941,397.00	6,258,603.00	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	67,306,200,000.00	67,299,941,397.00	6,258,603.00	100.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	67,306,200,000.00	67,299,941,397.00	6,258,603.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,360,113,640,700.00	1,359,684,746,753.24	428,893,946.76	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,359,453,912,400.00	1,359,175,685,835.00	278,226,565.00	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,359,453,912,400.00	1,359,175,685,835.00	278,226,565.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	659,728,300.00	509,060,918.24	150,667,381.76	77.2
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	480,000,000.00	348,533,591.24	131,466,408.76	72.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,000,000.00	83,297,174.00	1,702,826.00	98.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94,728,300.00	77,230,153.00	17,498,147.00	81.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(136,400,000,000.00)	(7,306,320,528.09)	(129,093,679,471.91)	5.4
230001	Эргэж төлөгдөх зээл	(136,400,000,000.00)	(7,306,320,528.09)	(129,093,679,471.91)	5.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,344,969,172,700.00	1,217,408,960,825.43	127,560,211,874.57	90.5
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,481,369,172,700.00	1,224,715,280,718.52	256,653,891,981.48	82.7
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,481,369,172,700.00	1,224,715,280,718.52	256,653,891,981.48	82.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	635.00	(635.00)	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	635.00	(635.00)	
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	(136,400,000,000.00)	(7,306,320,528.09)	(129,093,679,471.91)	5.4
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(136,400,000,000.00)	(7,306,320,528.09)	(129,093,679,471.91)	5.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	418,428,013,484.32	(418,428,013,484.32)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	170,365,956,393.44	(170,365,956,393.44)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	22	22	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	22	22	0.00	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	298	285	13.00	95.6
620001	Удирдах ажилтан	40	38	2.00	95.0
620002	Гүйцэтгэх ажилтан	258	247	11.00	95.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	295,884,445,326.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,136,189,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,189,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,989,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	89,989,000.00
212	ТАТААС	17,062,440,256.45
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	17,062,440,256.45
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	17,062,440,256.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	266,917,559,743.55
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	266,917,552,003.55
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	266,917,552,003.55
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,740.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	7,740.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,748,256,326.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,748,256,326.00
220001	Барилга байгууламж	-
221001	Их засвар	3,090,706,326.00
222001	Тоног төхөөрөмж	8,657,550,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	295,491,335,326.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	295,491,335,326.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	295,335,146,326.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	156,189,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 195,216.9 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 195,216.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 3 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Зөрчлийн нийт дүн 195,216.9 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 15,418.9 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д.д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн даатгалын сан	5	195,216.9			3	195,216.9	2	
	Дүн	5	195,216.9			3	195,216.9	2	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Д.д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Эрүүл мэндийн даатгалын сан							1	
	Дүн							1	